

“МОНГОЛ, АНУ-ЫН ХАРИЛЦАА ХХІ ЗУУНД: ИЖ БҮРЭН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦАА” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

*Д.Золбоо**

Монгол Улсын Гадаад хэргийн яам, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс хамтран “Монгол, АНУ-ын харилцаа 21 дүгээр зуунд: иж бүрэн түншлэлийн харилцаа” эрдэм шинжилгээний бага хурлыг 2007 оны 1 дүгээр сарын 26-нд Гадаад хэргийн яамны хурлын танхимд зохион байгуулав. Энэхүү эрдэм шинжилгээний бага хурал нь Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан цуврал арга хэмжээнүүдийн нэг байсан бөгөөд бага хуралд УИХ-ын зарим гишүүд, төрийн яам, газруудын холбогдох ажилтнууд, эрдэмтэд, судлаачид, ахмад дипломатчид, монгол-америкийн харилцааны түүх, байдал, төлвийг сонирхдог, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх асуудлыг анхаарч ажилладаг хүмүүс оролцов.

Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ач холбогдлын талаар хурлыг нээж УИХ-ын гишүүн, Гадаад хэргийн сайд Н.Энхболд хэлсэн үгэндээ: Монгол-Америкийн иж бүрэн түншлэлийн харилцаанд улс төр, худалдаа, эдийн засаг, аюулгүй байдал, соёл, боловсрол зэрэг бүх талын хамтын ажиллагааг хамруулан ойлгож байгаа хэдий ч цаашид энэ концепцийг тодруулах, гүнзгийрүүлэн ойлгох шаардлагатай. Үүнд энэ бага хурал тус дөхөм үзүүлж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын чиглэл, зорилтыг тодорхойлоход хувь нэмэр оруулна гэж тодорхойлсон байна.

Бага хуралд ГХЯ-ны Америк, Ойрхи, Дорнод, Африкийн газрын захирал Ц.Жамбалдорж “Монгол Улс, АНУ-ын харилцаа ХХІ зуунд: иж бүрэн түншлэлийн харилцаа”, АНУ-аас Монгол Улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд М.Минтон “Анд нөхөд ба хөршүүд: АНУ, Монголын харилцааны өнгөрсөн, одоо, ирээдүй үе”, ҮХЯ-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга В.Энхболд “Монгол Улс - АНУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал ба хэтийн төлөв”, Стратегийн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Др. Д.Мөнх-Очир “АНУ-ын 2008 он хүртэлх улс төрийн прогноз, Монгол Улс, АНУ-ын харилцааны хэтийн

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

төлөв”, Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Др.Ц.Баатар “АНУ-ын хөгжлийн тусламж Монголд”, БХЯ-ны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн В.Өлзийхуяг “Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа” сэдвээр тус тус илтгэл тавив.

Хурлын төгсгөлд оролцогчид илтгэлүүд болон бага хурлын сэдэвтэй холбогдсон асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэн ярилцав. Бага хурал Монгол-Америкийн иж бүрэн түншлэлийн харилцааны үзэл баримтлалыг тодруулах, гүнзгийрүүлэн ойлгоход тус дөхөм үзүүлж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын чиглэл, зорилтыг тодорхойлоход хувь нэмэр оруулсан арга хэмжээ боллоо гэж зохион байгуулагчид болон оролцогчид дүгнэв. Хурлыг хааж ГХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Х.Бэхбат хэлсэн үгэндээ, эрдэм шинжилгээний хурал тавьсан зорилтоо амжилттай биелүүлсэн бөгөөд илтгэгч нарын санаа, дүгнэлт болон ярилцлагын үед гарсан санал, зөвлөмжийг цаашдын ажилдаа анхаарч ажиллах болно гэж тэмдэглэн хэлсэн юм. Ойрын үед уг хурлын илтгэл болон холбогдох баримт бичгийг эмхтгэл болгон гаргаж олон нийтийн хүртээл болох ажээ.